

**Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны
хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд
хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн**
(2024 оны эхний хагас жилийн байдлаар, өссөн дүнгээр)

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” тус тус батлагдсан.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт КОВИД-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлогын “КОВИД-19 халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийг хүндрэлийг даван туулах арга хэмжээг хэрэгжүүлэх” зорилт; Хүний хөгжлийн бодлогын “Эрүүл мэнд, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах” зорилтын хүрээнд 2021-2024 онд Эрүүл мэндийн яам хэрэгжүүлэх нийт 99 арга хэмжээ байна.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт 2021-2024 онд эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлэх арга хэмжээ хүлээгдэж буй үр дүндээ хүрч байгаа эсэхийг нягтлах, арга хэмжээ тус бүрийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай санал, зөвлөмжийг боловсруулах, шийдвэр гаргагч нарт холбогдох мэдээлэл өгөх зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж гүйцэтгэсэн болно.

Хоёр. Хяналт-шинжилгээ үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлгээг хийж, журмын дөрөвдүгээр хавсралт ёсоор тайланг нэгтгэн гаргасан. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийг журмын 6.2.2, 6.2.3 дугаар заалтад заагдсан бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлэх аргачлалыг баримтлан арга хэмжээний хэрэгжилтийн хувиар тооцон гаргасан.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 2024 оны эхний хагас жилийн байдлаар (өссөн дүнгээр) 63.12 хувьтай үнэлэгдсэн.

2021-2024 онд төлөвлөгдсөн 99 арга хэмжээнээс 100 хувийн хэрэгжилттэй 41 (41.4%) арга хэмжээ, 90 хувийн хэрэгжилттэй 1 (1.0%) арга хэмжээ, 70 хувийн хэрэгжилттэй 15 (15.2%) арга хэмжээ, 50 хувийн хэрэгжилттэй 12 (12.1%) арга хэмжээ, 30 хувийн хэрэгжилттэй 11 (11.1%) арга хэмжээ, 0 хувийн хэрэгжилттэй 19 (19.2%) арга хэмжээ тус тус байна.

“Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 50 хувийн хэрэгжилттэй 12 арга хэмжээ байна. Үүнд:

1.1.2.7. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай холбоотой хийгдэх судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг батлуулах, судалгааны ажил болон санхүүжилтийг шийдвэрлүүлж, үр дүнг хүлээн авна (БТГ);

2.1.1.1. "Эрүүл, идэвхитэй амьдрал" арга хэмжээ хэрэгжүүлнэ 51.6 % (НЭМГ);

2.1.1.2. "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээ хэрэгжүүлнэ 49.8% (НЭМГ);

2.1.1.4. "Хавдрын эсрэг" арга хэмжээ хэрэгжүүлнэ (НЭМГ);

2.1.1.6. "Харшлаас сэргийлэх" арга хэмжээ хэрэгжүүлнэ 53.3% (НЭМГ);

2.1.2.2. Д вирустэй иргэдийг эмчилгээнд хамруулна (ЭТҮГ);

2.1.3.4. Геронтологийн төвийн барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулна (СЭЗГ);

2.1.8.1. Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл, хяналтыг нэвтрүүлнэ 50.4% (БТГ);

2.1.11.1. Барилга байгууламжийг барьж, тоног төхөөрөмжөөр хангах, хүний нөөцийг бүрдүүлнэ (БТГ);

2.1.12.3. Өрх, сумын эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн барилгыг шинэчилнэ (СЭЗГ);

2.1.13.3. Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид үйлчлүүлэгчийн хөндлөнгийн үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх, ил тод, нээлттэй болгоно (ЭТҮГ);

5.1.4.2. Аялал жуулчлалын бааз болон худалдаа, үйлчилгээний байгууллагуудын ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлага хангуулна (НЭМГ).

“Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30 хувийн хэрэгжилттэй 11 арга хэмжээ байна. Үүнд:

2.1.1.5. "Элэг бүтэн Монгол" арга хэмжээ хэрэгжүүлнэ 39.1% (ЭТҮГ, НЭМГ);

2.1.1.7. "Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээ хэрэгжүүлнэ 31.3% (НЭМГ);

2.1.4.1. Орон нутагт шаардлагатай газарт яаралтай тусламжийн цэг байгуулна (ЭТҮГ);

2.1.5.5. Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэхэд шаардлагатай дүрэм, стандартуудыг шинэчлэнэ (БТГ, НЭМГ);

2.1.5.6. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна (НЭМГ);

2.1.7.1. Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сан байгуулна (БТГ);

2.1.7.11. Төрөөс хариуцах иргэдийн шимтгэл, албан бус салбарын даатгуулагчдын хамрагдалт, шимтгэлийн хэмжээг өсгөх замаар Улсын төсөв (ЭМДС)-гийн орлогыг нэмэгдүүлнэ 33.3% (БТГ);

2.1.8.7. Биобэлдмэлийн үйлдвэрлэлийг эрчимжүүлнэ (БТГ);

2.1.8.9. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанар аюулгүй байдал, бүртгэл, засвар үйлчилгээний тогтолцоог бэхжүүлнэ (СЭЗГ);

2.1.10.1. Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, батлуулна (БТГ);

2.5.8.7. Гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настны хөгжлийн цогц төвүүдийг байгуулж, хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ (БТГ).

“Үр дүнгүй” буюу 0 хувийн хэрэгжилттэй 19 арга хэмжээ байна. Үүнд:

1.1.3.2. Шаардлагатай аймгуудад зоонозын өвчин судлалын төв, хил дагуух боомтод тандалтын нэгж байгуулна (НЭМГ);

1.1.3.5. Өвчний хяналт, сэргийлэлтийн төв байгуулна (БТГ);

2.1.2.1. "Элэг бүтэн Монгол" арга хэмжээний үр ашгийн судалгаа хийнэ (ЭТҮГ);

2.1.3.1. Эрхтэн шилжүүлэн суулгах төв байгуулна (СЭЗГ);

2.1.3.2. Зүрх судасны төв байгуулна (СЭЗГ);

2.1.3.3. Сүрьеэгийн эмнэлэг барьж, ашиглалтад оруулна 5.0% (СЭЗГ);

2.1.3.6. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цогцолбор салбар II байгуулна (СЭЗГ);

2.1.3.7. Хавдар судлалын үндэсний төвийн салбар II байгуулна (СЭЗГ);

2.1.3.8. Баянзүрх дүүрэгт 300 ортой эмнэлэг барина (СЭЗГ);

2.1.4.3. Яаралтай тусламж үйлчилгээнд агаарын үйлчилгээг (нисдэг тэрэг) нэвтрүүлнэ (ЭТҮГ, СЭЗГ);

2.1.5.7. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах лавлагаа төвийн чадавхыг нэмэгдүүлж, аймаг, дүүрэг Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулна (БТГ);

2.1.7.2. Төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад Улсын төсөв (ЭМДС)-өөс амбулатори, өдрийн эмчилгээ, оношилгоонд олгох санхүүжилтийн ялгааг арилгана 11.8% (СЭЗГ);

2.1.7.3. Урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар гаргаж, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаар гүйцэтгүүлэн, Улсын төсөв (ЭМД)-өөс санхүүжүүлнэ (БТГ);

2.1.7.7. Эрүүл мэндийн үндэсний тооцоо болон тусламж, үйлчилгээний тариф тогтооход ашиглах зорилгоор тусламж, үйлчилгээний өртгийн бүртгэлийн цахим тогтолцоог эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлнэ (БТГ);

2.1.8.4. Нянгийн тэсвэржилтийн хяналтын дэлхийн сүлжээнд нэгдэж, нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээг хянах тогтолцоог бүрдүүлнэ 4.0% (ЭТҮГ);

2.1.8.8. Эмийн аюулгүй байдлын үндэсний лаборатори байгуулна (БТГ);

2.1.9.4. Эрүүл мэндийн байгууллага цалин, урамшууллыг ёс зүй, харилцаа хандлагатай уялдуулж олгодог болсон байна (БТГ);

2.1.9.5. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлнэ (БТГ);

2.1.11.2. Ховд аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгын өргөтгөл барина (СЭЗГ).

Дөрөв. Дүгнэлт

1. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эрүүл мэндийн салбарын 99 арга хэмжээний хэрэгжилт 2024 оны эхний хагас жилийн байдлаар 63.12 хувийн үнэлгээтэй байна (өссөн дүнгээр).

2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 42 арга хэмжээний хэрэгжилт 0-50 хувийн үнэлгээтэй бөгөөд энэ нь нийт арга хэмжээний 45.4 хувийг эзэлж байна. Үүнээс 23 арга хэмжээний хэрэгжилт 30 болон 50 хувь буюу “Эрчимжүүлэх шаардлагатай” үнэлгээтэй, нийт арга хэмжээний 23.2 хувийг, 0 хувь буюу “Үр дүнгүй” үнэлгээтэй 19 арга хэмжээ, нийт арга хэмжээний 19.2 хувийг тус тус эзэлж байна.

3. Санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдээгүйгээс болон удирдлага, зохион байгуулалт хангалтгүй байгаагаас арга хэмжээний хэрэгжилт “Үр дүнгүй” болон “Эрчимжүүлэх шаардлагатай” гэсэн үнэлгээтэй байна.

4. Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд төлөвлөгөө баталсан бол төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тавих хяналтыг сайжруулах зайлшгүй шаардлагатай байна.

Тав. Зөвлөмж

1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр “Эрчимжүүлэх шаардлагатай” болон “Үр дүнгүй” байгаа арга хэмжээний хэрэгжилтийг 2024 оны сүүлийн хагас жилд эрчимжүүлэн ажиллах.

2. Газар, хэлтсийн дарга нар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, тавих хяналтыг сайжруулах.

3. Тайлагналтыг сайжруулж, шалгуур үзүүлэлтийн дагуу тодорхой, тоон үзүүлэлттэй, үр дүнд чиглэсэн, нотлох баримтад тулгуурлах.

4. Тухайн арга хэмжээтэй холбоотой нотлох баримтуудыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт өгч байх.

Эрүүл мэндийн яам
2023 оны 06 дугаар сар